



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 1/524

Чингис хот

Үндэсний бөхийн барилдаан зохион
байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сумын харьяат "Босоо" хэмээх Самдан аваргын нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 7000000 /долоон сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010978